



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 114

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглах боломжгүй нь тогтоогдсон, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 81,131,317.00 (наян нэгэн сая нэг зуун гучин нэгэн мянга гурван зуун арван долоон) төгрөгийн балансын үнэ бүхий 8 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001615



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 27 ны өдрийн
14 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашини нэр, марк, улсын бүртгэл, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт (км)	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуриртлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)
1. Дотоодын цэргийн 05 дугаар анги										
1	Яншин, 03-16 УББ (арал ljskc51e94d001286)	12/31/2006	57331	1	21,067,000.00	21,067,000.00	21,067,000.00	-	500,000.00	125,000.00
2	Тоёото хэррер, 03-04 УББ (арал msl100033253)	6/30/2010	268750	1	14,986,680.00	14,986,680.00	14,986,680.00	-	2,000,000.00	500,000.00
3	УАЗ 2206 фургон, 76-52 УБМ (арал w0472346)	10/6/2008	331547	1	14,600,000.00	14,600,000.00	14,600,000.00	-	300,000.00	75,000.00
4	ГАЗ-53, 03-17 УББ, (арал 1120311)	3/21/1989	316534	1	1,353,240.00	1,353,240.00	1,353,240.00	-	200,000.00	50,000.00
	Дүн				52,006,920.00	52,006,920.00	52,006,920.00	-	3,000,000.00	750,000.00
2. Замын цагдаагийн алба										
1	Мотоцикль	1/1/2002	70120	4	1,055,099.25	4,220,397.00	4,220,397.00	-	50,000.00	12,500.00
2	Мотоцикль (ХУ150-3 Policy)	9/30/2009	76868	2	1,200,000.00	2,400,000.00	2,400,000.00	-	50,000.00	12,500.00
3	2 дугуйт (segway 3)	9/30/2009	58633	1	11,252,000.00	11,252,000.00	11,252,000.00	-	50,000.00	12,500.00
4	2 дугуйт (segway)	9/30/2009	49856	1	11,252,000.00	11,252,000.00	11,252,000.00	-	50,000.00	12,500.00
	Дүн				29,124,397.00	29,124,397.00	29,124,397.00	-	200,000.00	50,000.00
	Нийт дүн				81,131,317.00 (наян нэгэн сая нэг зуун гучин нэгэн мянга гурван зуун арван долоон)	81,131,317.00 (наян нэгэн сая нэг зуун гучин нэгэн мянга гурван зуун арван долоон)	81,131,317.00 (наян нэгэн сая нэг зуун гучин нэгэн мянга гурван зуун арван долоон)	-	3,200,000.00 (гурван сая хоёр зуун мянган)	800,000.00 (найман зуун мянган)